

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС
НУТГИЙН ЭНХ ТАЙВАН,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ
ТЭМЦЭЛД**

(Дорнодахины Дугуй ширээ)

МАХН-ын XIX их хурал Ази, Номхон далайн бүс нутгийн улс төрийн амьдралын өнөөгийн байдалд гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, энэ бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс хоорондын харилцан итгэлцэх, хамтран ажиллах явдлыг хөгжүүлэх үйлсэд бүхий л аргаар тус дөхөм үзүүлэхийг манай нам, төрийн гадаад бодлогын үйл ажиллагааны нэн чухал чиглэл болохыг дахин нотолсон билээ. Энэ сэдвээр тус сэтгүүлийн редакци МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын ГЯЯ-ны зарим хэлтсийн эрхлэгчид, ЭТНБХ-ны Гүйцэтгэх Хорооны дарга, гадаад харилцаагаар ажиллаж буй зарим эрдэмтдийг оролцуулан зохиосон дугуй ширээний эчнээ ярилцлагын материалыг дор нийтлэв.

МАХН-ЫН ТӨВ ХОРООНЫ
ГАДААД ХАРИЛЦААНЫ
ХЭЛТСИЙН ЭРХЛЭГЧ
Л. РИНЧИН:

МАХН-ЫН XIX ИХ ХУРЛААС
ДЭВШҮҮЛСЭН ГАДААД БОДЛОГЫН
ЧИГ ШУГАМ, ТҮҮНИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛХМУУД

Дэлхий дахины улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжилд хэн ч зогсоож, эргүүлэн буцааж болшгүй тийм өөрчлөлт байнга гарч байсан, цаашид ч гарах нь зүй тогтол билээ.

Шинжлэх ухаан-техникийн эрчимтэй хөгжлийн өнөөгийн эринд ийм өөрчлөлт дэлхий нийтийг хамарсан шинж чанартай болж байгаагаар онцлог юм.

Дэлхийн бүх хуурай газрын бараг тэн хагас, хүн амын гуравны хоёрыг багтаасан Ази, Номхон далайн бүс нутагт энэхүү өөрчлөлт, шинэчлэлт хөгжлийн зүй тогтлын дагуу түргэн хурдацтай явагдаж байна.

XXI зууны эхээр энэ бүс нутаг дэлхийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн томоохон төвийн нэг болно гэдгийг судлаачид аль эрт тооцоолжээ. Нийгмийн хөгжлийн эргэлт буцалтгүй энэ процесс Ази, Номхон далайн бүс нутгийг улс төр-эдийн засгийн шинэ төв болгож яваандаа «Номхон далайн эрин» эхлэх боломжтой тухай ч улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэд олонтой ярьдаг боллоо. Ийм өөрчлөлт, ялангуяа улс төрийн өөрчлөлтийн эх суурийг одоогоос далан жилийн өмнө ялсан Аугаа их Октябрийн социалист хувьсгал тавьсан билээ.

Аугаа их Октябрийн хувьсгалын нөлөөгөөр Дорно дахины олон орнуудад үндэсний чөлөөлөх, тусгаар тогтнолын хөдөлгөөн өрнөж Дэлхийн II дайны дараагаар империализмын колоничлолын системийг задран унахад хүргэсэн юм. Чухам ийм учраас Ази, Номхон далайн бүс нутаг өнөө хүртэл улс төр, цэрэг, үндэсний хурц зөрчлийн зангилаа газар болсоор байна. Дэлхийн энэ бүс нутгийн энх

тайван, аюулгүй байдлыг хангах асуудлыг тулж ярилцахыг цаг үе шаардаж байна. Олон улсын харилцааны аливаа ээдрээтэй асуудлыг хүчээр тулган хүлээлгэж шийдвэрлэх гэдэг өнгөрсөн үеийн сэтгэлгээ пуужинт цөмийн өнөө эринд учир утгаа нэгэнт алдсан бөгөөд үүнийг түүхийн баримт итгэл үнэмшилтэй сануулж байна. Хэрэг дээрээ улс хоорондын маргааныг дайн хэзээ ч шийдвэрлэж байсангүй. Дайн, энхийн асуудалд философи-улс төрийн шинэ хандлага гарцаагүй шаардагдаж байна. Энэ нь олон улсын асуудалд улс төрийн шинэ сэтгэлгээгээр хандах хэрэгтэйг нийтээр хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үг юм. Улс түмнүүд бие биенээ харилцан ойлголцох, хамтдаа ажиллах, жинхэнэ итгэлцэл бий болгоход чиглэгдэж эцсийн дүнд хүн төрөлхтөн, түүний соёл иргэншлийг дайны аюулаас аврах тийм сэтгэлгээг бид улс төрийн шинэ сэтгэлгээ гэж ойлгож байна.

Ази бол хүний эртний соёл иргэншлийн нэг өлгий нутаг, ирмүүн ажил, нийгмийн шинэчлэл өөрчлөлтийн тив юм. Нөгөөтэйгүүр Ази тив ампериализмын хурц зөрчил, цэргийн мөргөлдөөний талбар болж байна гэж н. Ж. Батмөнх МАХН-ын Төв Хорооны бүгд хурал 1986 оны 12 дугаар сар) дээр дүгнэн хэлсэн юм.

— Ази, Номхон далайн улс хоорондын харилцаанд хүч үл хэрэглэх механизм бий болгох тухай манай улсын санал нь Азийн аюулгүй байдлыг хангах асуудалд иж бүрэн хандах тухай нөхөр М. С. Горбачевын дэвшүүлсэн санаа, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ЗСБНХУ, социалист бусад орнуудын гаргаж байгаа энх тайванч санал санаачилгатай шууд уялдаж байгаа юм. Улаанбаатарт зохион явуулсан Азийн орнуудын парламент, үйлдвэрчин, залуучууд, эмэгтэйчүүд, шашны байгууллагын төлөөлөгчдийн олон улсын уулзалтууд нь Ази тивд дайны эсрэг хөдөлгөөнийг өргөтгөн идэвхжүүлж, милитаризмыг сэргээх, зэвсэглэлээр хөөцөлдөхийн эсрэг тэмцэлд бүс нутгийн улс орны олон нийтийн өргөн давхаргыг татан оролцуулах зорилтод нийцсэн чухал алхмууд боллоо.

МАХН-ын XIX их хурал энх тайван, хамтын ажиллагааны төлөө нийт Азийн чуулга уулзалт хийх үзэл санааг дэмжээд Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Коммунист, ажилчны намын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалтыг бэлтгэн явуулахад идэвхтэй оролцоход бэлэн байгаага нотолсон билээ. 1987 оны долдугаар сарын 7-9-нд Улаанбаатар хотноо болсон Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын коммунист, ажилчны намын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалт нь бүс нутгийн намуудын анхны уулзалт болж тэдний эв санааны нэгдлийг илэрхийлснээр олон улсын ач холбогдолтой улс төрийн чухал үйл явдал юм. Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, сайн хөршийн хамтын ажиллагааны төлөө гэдэг уриан дор явагдсан энэ зөвлөлдөх уулзалтаас хийсэн зарчмын нэг чухал дүгнэлт бол Ази, Номхон далайн район дахь нэн ээдрээтэй нарийн төвөгтэй хурцадмал байдалд санал нэгтэй дүгнэлт хийж тийм байдлыг ялангуяа империализм, ялангуяа америкийн империалистуудын цэрэг дайны үйл ажиллагаа бий болголоо гэдгийг нотолсонд оршино. Ази, Номхон далайн бүс нутгийн коммунист, ажилчны намуудын хамтын ажиллагааны түүхэнд шинэ хуудас нээсэн Улаанбаатарын зөвлөлдөх уулзалт өнөөгийн нөхцөлд ЗСБНХУ болон социалист бусад орнуудын энх тайванч санал санаачилгуудыг хэрэгжүүлэхэд чухал нэг хүчин зүйл болгох, дайны эсрэг хөдөлгөөнд оролцож болох нийгмийн бүхий л хүчнийг дайчлан оролцуулах явдлыг уг бүс нутгийн коммунист, ажилчны намуудын хойшлуулшгүй зорилт гэж үзлээ.

Үүнтэй уялдан намуудын хоёр талын болоод олон талын уулзалтын журмаар санал бодлоо солилцох явдлыг цаашид тогтмолжуулахаар тохиролцсон нь Улаанбаатарын уулзалтын бас нэг чухал үр дүн юм. Энэ бол бүс нутгийнхаа энх тайван, аюулгүй байдлыг хамтын хүч чармайлтаар хангах зайлшгүй шаардлагыг Ази, Номхон далайн орнуудын улс түмэн улам бүр ухамсарлаж, цөмийн эрин үеийн бодит байдалд шинэ сэтгэлгээгээр хандах болж буйг харууллаа.

Бүс нутгийн маргаантай асуудлыг улс төрийн аргаар зохицуулах, харилцан итгэх уур амьсгал бий болгох зорилгоор авсан нэг практик арга хэмжээ бол Монголоос зөвлөлтийн цэргийн зарим ангийг гаргахаар ЗСБНХУ, БНМАУ хоёр шийдвэрлэж, уг шийдвэрээ хэрэгжүүлсэн явдал мөн.

МАХН-ын энх тайванч гадаад бодлогын чиг шугамыг хэрэгжүүлэх алхмууд өргөн цар хүрээтэй юм. Үүний нэг илрэл бол манай улсаас НҮБ-ын хүрээнд явуулж байгаа идэвхтэй үйл ажиллагаа болно. Манай засгийн газрын санаачилгаар энх тайван, зэвсэг хураах асуудлаар олон чухал тогтоол гарсны дотор олон улсын харилцааны түүхэн ач холбогдолтой баримт бичиг болох улс түмэн энх тайван орших эрхийн тухай тунхаглал батлагдлаа. Хоёр талын ба олон талын харилцааны баримт бичгүүд нь манай улсын гадаад үйл ажиллагааны чухал хэмжүүр болдог бөгөөд тэдгээрт МАХН-ын энх тайванч чиг шугам тусгалаа олж байдаг юм. Жишээ нь 1987 оны долдугаар сард нийтлэгдсэн Монгол-Афганистаны хамтарсан албан мэдээнд Номхон далайн өмнөд хэсгийг цөмийн зэвсэггүй бүс болгон тунхагласан Раротонгийн гэрээ хүчин төгөлдөр болсныг хоёр тал талархан тэмдэглээд Энэтхэгийн далайн асуудлаар олон улсын бага хурлыг 1988 онд хуралдуулахын төлөө байгаагаа санал нэгтэй илэрхийллээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх чиглэгдсэн бүхий л нааштай хандлагуудыг дэмжих нь манай намын гадаад бодлогыг хэрэгжүүлэх чухал хөшүүрэг болох юм. Хамтын ажиллагааны ийм өргөн далайцтай хэлбэрт цөмийн зэвсэггүй, хүчирхийлэлгүй ертөнцийн зарчмуудын тухай Зөвлөлт-Энэтхэгийн хамтарсан Делийн тунхаглал (1986 оны арван нэгдүгээр сар)-аас аваад Ази болон дэлхийн янз бүрийн район дахь хямралт байдлыг улс төрийн аргаар зохицуулахад чиглэсэн Варшавын гэрээнд оролцогч улсуудын цэргийн номнолын зарчмын заалтууд (1987 оны тавдугаар сар) хүртэл орж байна. Энд хамгийн шинэ сэргэг жишээ болгож ЗХУ-ын нутаг дэвсгэрийн Азийн хэсэг дэх дунд тусгалын болон оператив-тактикийн бүх пуужинг устгах боломжийн тухай М. С. Горбачеваас (1987 оны долдугаар сар) дэвшүүлсэн саналыг манай улс бүрэн дүүрэн сайшаан дэмжсэнийг дурдаж болох юм.

АСЕАН-ын орнуудтай сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх нөгөө талаар БНХАУ-тай харилцааг хэвийн болгох гэсэн Энэтхэг-Хятадын хойгийн ах дүү гурван орны саналууд, БНАСАУ-ын засгийн газраас дэвшүүлсэн эх орноо энх тайвнаар нэгтгэх, хоёр талын цэргийн хүчийг хорогдуулах тухай саналуудыг манай нам, засгийн газар тууштай дэмждэг билээ.

БНМАУ-дипломатын болон бусад шугамаар энх тайвны үйлсэд оруулж буй хувь нэмэр өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. Үүнд Монголын парламентын төлөөлөгчид 1986 онд Индонези, Малайзи, Австр рали, Шинэ Зеландад хийсэн сайн санааны үр дүнтэй айлчлалууд,

энэ оны 5-р сард БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Япон, Австрали улсуудад хийсэн айлчлал, хэлэлцээг дурдаж болох юм.

МАХН-ын XIX их хурлаас дэвшүүлсэн гадаад бодлогын чиг шугам, түүнийг хэрэгжүүлж буй алхмуудыг дэлхийн олон нийт, НҮБ, ах дүү коммунист, ажилчны намууд талархаж, өндөр үнэлж байгааг хэлэхийн хамт бат бэх энх тайван, аюулгүй байдлыг хангах үндсийн үндэс, «тулгын чулуу» нь улс хоорондын харилцаанд хүч хэрэглэхгүйгээр аливаа маргаантай асуудлыг гагцхүү улс төрийн аргаар зохицуулах явдал гэж үздэг намынхаа гадаад бодлогын ленинч жанжин шугамыг хэрэгжүүлэхэд манай улс цаашид ч идэвхтэй үүрэг биелүүлж, Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бүрэлдүүлэн тогтоох үйлсэд өөрийн хувь нэмэр оруулах болно.

ЭТНБХ-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ХОРООНЫ ДАРГА
Д. ЦАХИЛГААН, ТҮҮХИЙН
УХААНЫ ДЭД ЭРДЭМТЭН:

АЗИЙН ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ТӨЛӨӨ ОЛОН НИЙТИЙН
ХӨДӨЛГӨӨНИЙ ЗАРИМ АСУУДАЛ
ЗОРИЛТЫН ТУХАЙ

Дэлхий дахины өргөн олон нийтийн ардчилсан хөдөлгөөн, түүний дотор энх тайвны төлөө, дайны эсрэг, цөмийн аюулын эсрэг хөдөлгөөний өсөлт бол манай үеийн нэг онцлог шинж юм.

Дайныг эсэргүүцсэн өргөн ард олны хөдөлгөөн ЗХУКН-ын шинэчлэн боловсруулсан программд заасанчлан «нийгмийн амьдралд урт хугацааны нөлөө бүхий хүчин зүйл» болж байна. Энэ хөдөлгөөн улам бүр идэвхжиж, олон нийтийг хамарч, зохион байгуулалттай болж, нийгэм, улс төрийн янз бүрийн хүч оролцуулж байгаагаараа онцлогтой болохыг МАХН-ын XIX их хурал тэмдэглэсэн билээ.

Дэлхий дахины үйл явцын өрнөлт хөгжилтөд чухал нөлөө бүхий энэхүү өргөн хөдөлгөөний бүрэлдэхүүн хэсгийн хувьд манай орны олон нийт, түүний дотор энх тайван, найрамдал, эв санааны нэгдлийн байгууллагуудын үүрэг хариуцлага өнөө үед ихээхэн өсөн нэмэгдэж байна.

Ялангуяа манай нам, төрийн гадаад бодлогын үйл ажиллагааны нэн чухал чиглэл болсон «Ази тивийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, энэ бүс нутгийн улсуудын харилцан ойлгох, хамтран ажиллах явдлыг хөгжүүлэх үйлсэд бүхий л аргаар тус дөхөм үзүүлэх явдал» олон нийтийн байгууллагуудын нэг гол зорилт болж ирлээ.

Манай орны олон нийтийн байгууллага (ОНБ)-ууд энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс ЗХУ, ах дүү социалист орнуудын холбогдох байгууллага, ДЭТЗ, ААЭСНБ, ДҮЭХ, ДАЗХ, ДАЭХ зэрэг олон улсын ардчилсан байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж нэлээд ажил зохиож байна.

Өнгөрсөн жилүүдэд эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүд, энх тайван, найрамдлын байгууллагууд эх орондоо олон улсын хурал зөвлөлгөөн нэлээдийг зохиож гадаадад болсон ийм арга хэмжээнүүдэд идэвхтэй сролцож ирлээ. Эдгээр хурал зөвлөлгөөний баримт бичигт ЗХУ, ах дүү социалист орнууд, түүний дотор манай орны энх тайванч санал санаачилгын талаар байнга тэмдэглэж, дэмжсэн тусгай тогтоол гаргаж байгаа нь тэдгээрийн ач холбогдол улам бүр өсөж дайны

эсрэг өргөн олон нийтийн хөдөлгөөний чиг замыг зааж байгааг харуулж байна.

Дэлхий дахины үйл явцын өрнөлт, олон улсын амьдралын сүүлийн үеийн томоохон үйл явдлууд нь Ази, Номхон далайн орнуудад дайны эсрэг хөдөлгөөнийг улам эрчимтэй өрнүүлэн, хүчин чадлыг нь бүрэн гүйцэд ашиглаж чадвал тодорхой үр дүнд хүрэх бололцоо байгааг харуулж байна.

Нийт тивийн хэмжээгээр авч үзвэл дайныг эсэргүүцсэн төрөл бүрийн арга хэмжээ Азид олширч байгаа нь тэмдэглүүштэй юм. Сүүлийн үед социалист орнуудаас гадна Энэтхэг, Япон, Австрали, Шинэ Зеланди, Филиппин зэрэг орнуудад энх тайвны төлөө цөмийн дайны эсрэг хөдөлгөөн идэвхжиж байна. Дайны эсрэг хөдөлгөөний идэвхжилтэнд ЗХУ, социалист бусад орнуудаас дэвшүүлж буй энх тайванч санал, санаачилга, оновчтой үйл ажиллагаа таатай нөлөө үзүүлж, тэдний тэмцлийг улам бүр зоригжуулж байна. Түүнчлэн ДЭТЗ, ААЭСНБ зэрэг ардчилсан байгууллагуудаас Ази, Номхон далайн орнуудын үндэсний байгууллага, энхийг эрхэмлэгч хүчинтэй хэлхээ холбоогоо өргөжүүлж байгаа нь сайн нөлөө үзүүлж байгаа юм.

Гэхдээ Ази, Номхон далайн районы хувьд дайны эсрэг хөдөлгөөн нэлээд өвөрмөц шинжтэй, зарим талаар сул дорой байгаа явдал бий. Үүний шалтгаан нь улс төр, эдийн засаг, үзэл суртал, шашин шүтлэг зэрэг олон зүйлд байна.

Ази тивд дайны эсрэг хөдөлгөөнийг өргөтгөн идэвхжүүлж, милитаризмыг сэргээх оролдлого, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлын эсрэг тэмцэлд энэ бүс нутгийн олон нийтийн өргөн давхрагаас татан оролцуулах, хамтын хүчин чармайлтаар цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулж, энх тайван, аюулгүй байдлыг тогтооход манай намын сүүлчийн их хурлаас санал болгосон Азийн орнуудын өргөн олон нийтийн төлөөлөгчид оролцсон энх тайван, хамтын ажиллагааны төлөө нийт Азийн чуулга уулзалт хийх явдал чухал ач холбогдолтой юм. Үүнийг энэ онд манай намын санаачилгаар Улаанбаатарт болсон Ази, Номхон далайн орнуудын коммунист, ажилчны намын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалтаас цохон тэмдэглэснийг дурдах хэрэгтэй.

Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд олон нийтийн шугамаар зохиох ажлын агуулга, чиглэл тодорхой юм. Энэ бол ЗХУКН-ын XXVII МАХН-ын XIX их хурал, ах дүү намуудын сүүлчийн их хурлаас дэвшүүлсэн энх тайванч санал санаачилгыг сурталчлан хэрэгжүүлэх, социалист орнуудын нэгдмэл байр суурийг тууштай хамгаалах явдал юм. Азийн чиглэлд явуулж байгаа ЗХУ-ын бодлого, энх тайванч хүч чармайлт, оновчтой санал санаачилга манай намын сүүлчийн их хурлуудаас боловсруулсан чиг шугамтай таарч манай ард түмний эрх ашигт бүрэн нийцэж байна.

Азийн аюулгүй байдлыг нийт дэлхийнхээс салгаж үзэх аргагүй. Иймээс манай гаригийн дэвшилт хүч, шударга хүн төрөлхтний өмнө тавигдаж байгаа цөмийн аюулыг зайлуулах нийтлэг зорилт бол тив бүс нутгийнханд нэг адил хамаарах нь гарцаагүй. Энэ өргөн утгаар авч үзвэл цөмийн аливаа дэлбэлэлтийг хориглох, цөмийн зэвсэггүй бүс нутаг, улс орон хот суурин, муж район бий болгох, америкийн түрэмгий цэргийн баазыг зайлуулах бүх хөдөлгөөнийг дэмжих, цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг газар дэлхийд болон сансрын уудамд таслан зогсоож, Рейганы «Оддын дайны» төлөвлөгөөг нураахад бүх ажлыг, олон нийтийн бүх хүч чармайлтыг төвлөрүүлэх явдал манай тив, бүс нутгийн энх тайвны хөдөлгөөний гол зорилт мөн.

Нөгөө талаар, Ази, Номхон далайн бүс нутгийг олон улсын аюулгүй байдлын бүх талыг хамарсан системд хамруулах тухай ЗХУ, ах дүү социалист орнуудын нэгдмэл үзэл баримтлалыг бодит байдал болгохын төлөө тэмцэл нэн чухал ач холбогдолтой юм.

Ази, Номхон далайн аюулгүй байдлыг хангах бодит арга замыг зөвлөлтийн удирдагч М. С. Горбачев өнгөрсөн жил Владивосток хотод хэлсэн үгэндээ тодорхой заан тодорхойлсон бөгөөд саяхан Индонезийн сонины асуултад хариулахдаа уг асуудлыг бүр ч нарийвчлан авч үзэж программын шинжтэй энх тайванч шинэ санаачилга дэвшүүллээ. Энэ нь ах дүү социалист орнуудын уялдуулан зохицуулсан энх тайванч үйл ажиллагаа, дайны эсрэг олон нийтийн хөдөлгөөний чухал чиглэл болж өглөө.

Одоо юуны өмнө Зөвлөлт болон социалист орны бодлогын үнэн зөв, шударга зарчимтайд гадаадын олон нийтийг итгүүлэх талаар их зүйл хийх ёстой. Энэ бол бидний гадаадад зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлыг эрс нэмэгдүүлэх, чанаржуулах хэрэгтэй гэсэн үг.

Олон улсын ардчилсан байгууллагуудын үйл ажиллагаанд Азийн чиглэлд хийх зүйлийг нэмэгдүүлэх талаар чармайх нь бид бүхний анхааралд байх ёстой.

Нөгөө талаар үндэсний байгууллагуудтай ойртон ажиллах, тэднийг идэвхжүүлэхэд тус дэмжлэг үзүүлэх явдал чухал юм.

БНМАУ-ЫН ГЯЯ-НЫ ХЭЛТСИЙН
ДАРГА Ж. ЧОЙНХОР,
ТҮҮХИЙН УХААНЫ ДЭД
ЭРДЭМТЭН:

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮХНИЙГ
ХАМАРСАН СИСТЕМД ХОЛБОГДОХ
УЧИРТАЙ

Олон улсын аюулгүй байдлын бүхнийг хамарсан системийг бий болгох зорилт нийт улс түмний язгуур эрх ашигт нийцэж байгаа бөгөөд тийм системийг байгуулах тодорхой арга замыг сүвэгчлэн олох нь өнөөгийн тулгамдсан асуудал болжээ. Бүх нийтээр амар амгалан аж төрөх эрмэлзлэл бол аливаа ард түмний чин хүсэл билээ. Зөвхөн дэлхийн II дайнаас хойш гэхэд энэ л зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагыг үүсгэн байгуулсан. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн өрнөж олон улсын харилцааны чухал хүчин зүйл болсон билээ. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн маань мэдээжээр эвсэл үүссэний дараа л бий болсон хэрэг. Эхлээд «бүх нийтийн аюулгүй байдлыг сахин амгаална», «үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлнэ» гэдэг нэрийд зар дэлхийн сүүлчийн дайны дараах цэргийн анхны хүчирхэг эвсэл бий болсон. Үүний дараа үнэнхүү энд дурдсан зорилгын үүднээс, ер арга зам үлдээгүйн учир, ах дүү орнуудын батлан хамгаалах хамтын байгууллага бий болсныг дэлхийн дэвшилт олон нийт, түүний дотор монголын хөдөлмөрчид сайн мэдэх билээ.

Цэргийн эвсэл холбоо байгуулж, зэр зэвсгээ хичнээн ч нэмэгдсэн эцсийн эцэст нийт хүн төрөлхтний амгалан ирээдүйг хангах боломжгүй гэдгийг дэлхийн хөгжлийн сүүлийн 40 гаруй жилийн туршлага харууллаа.

Шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй хөгжил, цөмийн эрин, сансрын зууны дэвшлийн нэг онцлог үр дагавар бол аливаа орон, хичнээн ч хүчирхэг байлаа гэсэн, ямар ч төгөлдөр зэвсэгтэй байлаа

гэсэн үндэсний аюулгүй байдлаа дан ганцаар бүрэн хангаж чадахгүй болсон явдал юм. Ийм бодит байдлыг ухаалгаар харгалзан үзэх үндсэн дээр өнөөгийн улс төрийн шинэ сэтгэлгээ, дипломат бодлогын шинэ арга барил үүдэн гарч байна.

Чингэхлээр олон улсын аюулгүй байдлын бүхнийг хамарсан системийн урд өмнө нь дэвшүүлж байсан санал, баримталж байсан чиг баримжаанаас ялгарах үндсэн шинж чанар нь юу вэ гэвэл: эл системд ганц хоёр тив, бүс нутаг, бүх улс гүрэн хамрагдаад зогсохгүй, чухамхүү бүх тив, бүс нутаг, бүх улс гүрэн иж бүрэн хамрагдах ёстой. Тэгж гэмээнэ бүх нийтийн тохиролцоонд хүрэх боломжтой агаад нөгөөтэйгүүр олон улсын аюулгүй байдлын бүхнийг хамарсан системийн зарчмын үндсүүд нь улс гүрний үйл ажиллагааны гол гол чухам хэлбэл цэрэг, улс төр, эдийн засаг, хүнлэг ёсны зэрэг бүхий л салбарыг хамрах учиртай.

Бүхнийг хамарсан эл системд дэлхийн хүн амын тэн хагас нь оршин сууж буй өргөн уудам Ази, Номхон далайн бүс нутаг, энд байгаа нийт улс гүрэн оролцож гэмээнэ бодит үр дүнд хүрэх нь нэн тодорхой. Ази, Номхон далайн бүс нутагт нийгмийн өөр өөр байгуулалтай улс гүрэн, улс төрийн чиг баримжаа, эдийн засаг, соёлын хөгжлийн төвшин өөр өөр орнууд, хөгжингүй, хөгжиж байгаа, цөмийн зэвсэгтэй зэвсэггүй, том жижиг янз бүрийн улсууд байдаг бөгөөд энэ районд ЗХУ, АНУ, Хятад, Япон, Энэтхэг, Индонез зэрэг томоохон гүрнүүд оршиж байгаа нь аандаа уг районуыг дэлхийн бодлогын нэгээхэн чухал зангилаа болгон хувиргаад байна. Нэгэн зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн стратегийн чухал ач холбогдол нь олон улсын харилцаанд түүний эзлэх байр суурийг тодорхойлж байна. Энэ бүс нутагт энх тайван, нийгмийн дэвшлийн хүчнүүд жил тоолон өсч амжилтаас амжилтад хүрч байгаа нь тэмдэглэлтэй чухал хандлага юм. Ази, Номхон далайн бүс нутагт дэлхийн худалдааны 30 гаруй хувь ногдож байгаа бөгөөд хар тугалга, зэс, цайр зэрэг чухал металлын илрэгдсэн нөөцийн 30-50 хувь нь байна гэж үздэг. Зөвхөн Номхон далайн сав газарт гэхэд дэлхийн далайн ёроол, эх газрын хормойд байгаа нефть, байгалын хийн тооцоолж байгаа нөөцийн 40 орчим хувь нь ногдож байна. Азийн нэлээд оронд эдийн засаг, шинжлэх ухаан, техник үсрэнгүй хөгжиж байна.

Энэ бүхнээс үзэхэд Ази, Номхон далайн бүс нутагт худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа, хамтын ажиллагаа зайлшгүй, тэр тусмаа эрчимтэй хөгжих бодит нөхцөл бүрдсэн нь харагдаж байна. Үүнд тулгуурлан эл бүс нутагт нийгэм, улс төрийн харилцаа идэвхжиж, дипломатын үйл ажиллагаа өргөжих нь зүй ёсны хэрэг.

Манай гаригийн таван тив ус далайгаар хоорондоо зааглагдсан боловч тивүүдийн аюулгүй байдал өөр хоорондоо нягт холбоотой, харилцан шүтэлцээтэй билээ. Тийм ч учраас энх тайвны үл хуваагдах чанарын тухай зарчимт сургаалийн агуулга нь дэлхий дахинаа болж буй үйл явдал нэг нь нөгөөгөөсөө шалтгаалж, харилцан нөлөөлөх деаликтик холбоотой байдагт оршино.

Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахин хангах нь социализмын орнуудын гадаад бодлогын нэн чухал чиглэл мөн. Зөвхөн сүүлийн 2 жилийн дотор ЗХУ, социалист бусад орноос энэ бүс нутгийн энх амгалан байдлыг хангахад чиглэсэн санал, санаачилга, хэрэгжүүлсэн практик алхмуудыг авч үзэхэд дээр дурдсаныг бэлхнээ нотолж байна. Манай бүс нутгийн янз бүрийн

хэсэгт хурцадмал байдал, нарийн төвөгтэй асуудлуудыг эв зүйгээр шийдвэрлэх талаар оновчтой арга хэмжээ хэрэгжсээр ирлээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг нийтийн хүч чармайлтаар хангахын тулд Зөвлөлт Холбоот улсаас 1985 онд дэвшүүлсэн Азийн аюулгүй байдлыг хангах асуудалд иж бүрэн хандах тухай чухал санаа, Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг хангах талаар 1986 онд дэвшүүлсэн Владивостокийн программ, мөн онд ЗХУ, Энэтхэгийн удирдагчид гарын үсэг зурсан «Дэлхийг цөмийн зэвсэг, хүчирхийллээс ангижруулах зарчимуудын тухай Делийн Тунхаглал», 1987 онд Индонезийн «Мердека» сонин асуултад нөхөр М. С. Горбачевын өгсөн хариунд дэвшүүлсэн санал нь азийн улс түмний эрх ашигт бүрэн нийцэж байгаа бөгөөд Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын концепцийн үндсийг бүрэлдүүлж, хэрэг дээрээ энэ районд олон улсын байдлыг хэвийн, найрсаг урсгалд оруулах практик арга хэмжээний дорвитой эхлэл болж өглөө.

Ази тивийн улс түмэн дайны эсрэг, энх тайвны төлөө тэмцлийн баялаг уламжлалтай билээ. Түүхт Бандунгийн бага хурал, түүнээс баталсан 10 зарчмыг эргэн санахад л хангалттай жишээ даруй мөн. Гэвч орчин цагийн байдлыг үзэхүл, Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын байдал нарийн төвөгтэй, зарим хэсэгтээ туйлын ноцтой байгааг анхаарахгүй байхын аргагүй юм. Байдал ийм байтал манай бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахиулах зорилго бүхий улс гэрийн хамтын ажиллагааны, энэ тивээ хамарсан ямар ч байгууллага, механизм байхгүй байгаа нь нэн харамсалтай байна.

Саяхан Улаанбаатар хотноо болсон Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Коммунист, ажилчны намуудын анхны зөвлөлдөх уул залтаас гаргасан төгсгөлийн баримт бичигт: «Империализмыг эсэргүүцсэн бүс нутгийн улс түмний тэмцлийн уламжлалыг арвижуулж, улс орнуудын аюулгүй байдлыг хангаж, энх тайванч хамтын ажиллагаа тогтоох үйл хэрэгт бусад тивийн орнуудын хуримтлуулсан туршлагыг ашиглах нь чухал байна» гэж манай бүс нутгийн улс түмний энх тайвны төлөө тэмцлийн зорилтыг тодруулан заасан билээ.

МАХН, БНМАУ-ын хувьд Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл хэрэгт бүхий л талаар тус дэмжлэг үзүүлж, түүнд идэвхтэй оролцох нь манай нам, төрийн гадаад бодлогын энх тайванч, интернациональч мөн чанараас урган гарч байгаа зорилт мөн.

МЭДН-ИЙН ХАРИУЦЛАГАТАЙ
АЖИЛТАН Б. БАТБОЛД,
ТҮҮХИЙН УХААНЫ ДЭД
ЭРДЭМТЭН:

АЛС ДОРНОДЫН ЭНХ ТАЙВАН,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАНГИЛАА
АСУУДАЛ

Сүүлийн үед Ази, Номхон далайн район, түүний дотор Алс Дорнодын байдал нь тус тив бүс нутгийн түгшүүртэй голомт болсоор байгаа нь дэлхийн дэвшилт олон нийтийн санааг гүнээ түгшүүлж байна.

АНУ-ын засаг, захиргаа, тухайлбал Батлан хамгаалах Яамны сайд Г. Уайнбергериин хэвлэлийн нэгэн сурвалжлагчид өгсөн ярилцлагаас авах ч гэсэн Алс Дорнод нь «Европын дараа орж байгаа америкийн чухал эрх ашиг, сонирхлын бүс болжээ.

Дэлхийн харгис хүчин сүүлийн жилүүдэд Алс Дорнодыг яаралтайгаар милитаричилж байгаа нь тус тив бүс нутгийг ЗХУ болон социалист бусад улс оронтой сөргөлдөх гол талбар гэж үзэж байгаатай шууд холбоотой. АНУ нь тус тив бүс нутгийг өөрийн эрх ашиг, сонирхлын хүрээндээ оруулахын тулд янз бүрийн ов мэхнээс эхлээд цэрэг зэвсгийн хүчээр түрий барих, халдан довтлох зэрэг бүхий л аргыг хэрэглэсээр ирсэн юм.

Өнөөгийн байдлаар энэ бүс нутагт АНУ урьд өмнө үзэгдээгүй их хэмжээний цэрэг, зэвсгийг бөөгнөрүүлж байна. Цэрэг зэвсгийн хүчин чадлаар Баруун Европын дараа хоёрт ордог энэ бүс нутагт жилд 40 млрд. орчим долларыг цэрэг, зэвсгийн зориулалттай зарж байна.

Гадаадын зарим хэвлэлийн мэдээнээс үзвэл Алс Дорнодод цэргийн 300 гаруй бааз, АНУ-ын 150 мянга орчим цэрэг, офицер байгаа ажээ. Бас эндхийн усан районд АНУ-ын байлдааны 200 гаруй хөлөг онгоц, усан доогуур шумбагч онгоц олон арваар байна. Номхон далай дахь АНУ-ын тэнгисийн цэргийн 7-р флотын бие бүрэлдэхүүн 1983 онд 17,5 мянга байсан бол 1986 оны байдлаар 40 мянгад дөхөж очжээ.

АНУ-ын эрх баригчид «Япон бол Америкаас Азид явуулах бодлогын тулгын чулуу төдийгүй дэлхийн тавцан дээрх манай гол түнш» гэж үзэж Америк-Японы харилцаа, хамтын ажиллагааг ихэд өргөжүүлэхээр тооцоолж байна. Энэ төлөвлөгөөгөө тэд АНУ-Японы хоорондох «Аюулгүйн гэрээ» гэгчид түшиглэн хэрэгжүүлж байна. Сүүлийн жилүүдэд АНУ-ын нөлөөн дор Японы гадаад бодлогод нэлээд өөрчлөлт орж милитарист түрэмгий чиг шугам илтэд давамгайлах болсон билээ.

Японы эрх баригч бүлгийнхэн удаа дараалан АНУ-д очиж цэрэг улс төрийн хэлхээ холбоогоо улам ойртуулан Японыг «нисэх онгоц тээгч жившгүй хөлөг онгоц» болгохоо амлаж байна.

Японы Засгийн газар сүүлийн жилүүдэд цэргийн зардлаа үлэмж нэмэгдүүлж байгаа бөгөөд 80-аад оны эцэс гэхэд 25—30 миллиард долларт хүрэх ажээ.

Гадаадын хэвлэлээс үзвэл Японд пентагоны 119 бааз (үүнээс томоохон бааз нь 40 орчим) байгаа юм. Японы цэргийн аж үйлдвэр нэлээд хурдтай хөгжиж байгааг бас тэмдэглэж байна.

Японы засгийн газрын тунхаглаж байгаагаар Японы эргийн эргэн тойронд 1000 бээрийн газарт хяналт тавих, дайн байлдааны ажиллагаа явуулах эрхтэй гэх «номлол» нь өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарч, хойт талаараа ЗХУ-ын Алс Дорнод, баруун талаараа Солонгосын хойг, Өмнөд талаараа Тайвань, Филиппин, Малайз, зүүн талаараа Гуамын аралд тус тус хүрч байгаа юм. Энэ бол бусдын нутаг дэвсгэрт, олон улсын далай тэнгисийн усанд эзэрхийллээ тогтоох гэсэн өнгөлзөх санаархал бүхий оролдлогын тод илрэл билээ.

АНУ-ын засаг захиргааны «Оддын дайны» төлөвлөгөө гэгчид Япон улс НАТО-гийн гишүүн зарим орнууд болон Америкийн гол холбоотон хамсаатнуудын хамтаар нэгдэн орсон явдал аюултай алхам болов. Рейганы засаг захиргааны сансрыг милитаричлах балмад төлөвлөгөөг Японы милитаристууд ихэд хөхүүлэн өөгшүүлж байна.

СБХС буюу оддын дайны программд оролцох асуудлаархи Японы засгийн газрын сүүлийн үед хийсэн алхам бол бүх нийтийн энх тайван аюулгүй байдалд заналхийлсэн аюулт хэрэг мөн.

Япон улс орчин үеийн цэргийн томоохон гүрэн болж Вашингтон Токио-Сеул гэсэн цэргийн гурамсан холбооны төлөвлөгөөнд гүйцэтгэх үүрэг нь улам өсч Ази тивд давамгайлах байдалтай болжээ. Энэхүү гурамсан холбоо гэгч нь «Номхон далайн хамтын нийгэмлэг» хэмээх нэрийн дор яваандаа НАТО-гийн нэгэн хувилбар болох учиртай оролдлого хийгдэж байгааг гадаадын зарим хэвлэл тэмдэглэж байгаа нь бас л учиртай.

АНУ цэрэг-стратегийн милитарист бодлогоо Алс Дорнодод илт хэрэгжүүлэх гэж оролдож байгаагийн нэг тод илрэл бол Өмнөд Солонгосыг цөмийн заналхийлэлийн түшиц газраа болгож, тэнд цөмийн олон зуун цэнэг, тэдгээрийн байнд хүргэх хэрэгслийг олон тоогоор байрлуулж байгаа явдал билээ. Вашингтоныхон саяхан Өмнөд Солонгосын нутагт «Лэнс» пуужин байрлуулах шийдвэр гаргасан явдал бол дэлхийн янз бүрийн бүс нутагт эзэрхийлэлийн байрлалаа эхжүүлэхийн үүднээс цэрэг зэвсгийн баазаа өргөжүүлж гар хөл бологчдоо шинэ шинэ зэвсгээр хангасаар байгааг нотлох баримт мөн.

АНУ-ын засаг захиргаа, Пентагоны эрх баригчид Өмнөд Солонгост шинэ ангилалын зэвсэг байрлуулсан явдал бол ЗХУ, БНАСАУ-д шууд заналхийлж байгаа төдийгүй Алс Дорнод, улмаар Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг тогтворгүй болгож энэ бүс тутагт цөмийн зэвсэг нэмэгдүүлэн дэлгэрүүлэхийг эсэргүүцсэн өргөн олон нийтийн үзэл бодол, үйл ажиллагааг үл ойшоосон илэрхий өдөөн хатгалага мөн.

Америкийн цөмийн зэвсгийг Өмнөд Солонгост байрлуулсны улмаас учрах уршиг, дагаврын хариуцлагыг АНУ-ын засаг захиргаа шууд хүлээх ёстой гэж Монголын ард түмэн, дэлхийн шударга олон нийтийн адилаар үзэж байна.

Дэлхийн дэвшилт олон нийтийг түгшээж байгаа асуудал бол америк-япон өмнөд Солонгосын цэргийн хамтарсан сургуулийг тус бүс нутагт үлэмж хэмжээтэй хийж байгаа явдал мөн. «Тим спирит», «Ямато» зэрэг нууц нэртэй байнга шахам хийдэг олон сургуулийг нэрлэж болно.

АНУ Солонгосын хойгийн өмнөд хэсгийг зэвсгийн томоохон сан болгох алхам хийж байгааг нотлох баримт бол 1000 гаруй цөмийн нэгж зэвсэг, Америкийн 40 мянга гаруй цэргийн албан хаагч байгаа явдал мөн. Өмнөд Солонгосын харгис дэглэм өөртөө 700 мянга гаруй цэргийн бие бүрэлдэхүүнтэй армитай байгаа нь Азид хамгийн их хүнтэй зэвсэгт хүчин бүхий хөрөнгөтөн орон болж байна.

Вашингтоныхон ийнхүү Азийн, түүний дотор Алс Дорнодын түгшүүртэй байдлыг хурцатгах сөргөлдөх бодлогоо явуулсаар байна. Гэвч Алс Дорнодыг энх тайван, тогтвортой байдлын бүс болгохын төлөө ЗХУ, социалист орнууд, энхийг эрхэмлэсэн хүчин тууштай тэмцэл явуулж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Дэлхий дахины улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг хазаарлан зогсоох, цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлуулах талаар социалист орнуудын гаргаж байгаа хүчин чармайлт олон улсын байдал хурцадсан өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой байна.

Ялангуяа ЗХУКН-ын XXVII их хурлаас дэвшүүлсэн олон улсын аюулгүй байдлын бүх талыг хамарсан систем нэн чухал билээ. 1986 на VII сарын 28-нд М. С. Горбачев Владивосток хотноо үг хэлэхдээ Ази, Номхон далайн районыг, түүний дотор Алс Дорнодыг энэдээ багтаах тухай санал дэвшүүлсэн нь цаг үеэ олсон зүй ёсны санал болсон юм. Түүнчлэн Солонгосын хойгийг тогтвортой байдлын

бүс болгож Солонгосын асуудлыг тайван замаар шийдвэрлэх гэсэн БНАСАУ-ын санал тун чухал билээ.

Солонгосын хойг дахь цэргийн сөргөлдөөнийг багасгаж, түгшүүрийг намжаан байдлыг тогтвортой болгох нь Алс Дорнод болон нийт Азид аюулгүй байдлыг найдвартай хангахын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй, энх тайвны бүс болгох, Өмнөд Солонгос АНУ-ын бүх цэрэг зэвсгийг, түүний дотор цөмийн зэвсгийг гаргах, Солонгост гал зогсоосон тухай хэлэлцээрийг энх тайвны хэлэлцээр болгох, тус орны Умард, Өмнөд хэсгийн хооронд харилцан үл довтолох тухай тунхаглал гаргах, тэдгээрийн хооронд энх тайвны өргөн яриа хэлэлцээ явуулан хөгжүүлэхэд чиглэсэн БНАСАУ-ын энх тайванч санаачилгуудыг монголын ард түмэн, БНМАУ-ын засгийн газар тууштай дэмжиж байна. БНАСАУ-ын энх тайванч санаачилгуудыг Монголын ард түмэн, БНМАУ-ын засгийн газар тууштай дэмжиж байна. БНАСАУ-ын эдгээр саналыг хэрэгжүүлбэл Солонгосыг энх тайвнаар, ардчилсан үндсэн дээр нэгтгэх таатай уур амьсгалыг бүрдүүлэх, тэгснээрээ зөвхөн Солонгосын хойгт төдийгүй, Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж бэхжүүлэх хэрэгт чухал хувь нэмэр болно.

ЗХУ, социалист орнууд болон энхийг эрхэмлэсэн улс орнуудын энх тайванч, оновчтой санал, санаачилгыг амьдралд хэрэгжүүлбэл дэлхийн улс төрийн байдлыг эрүүлжүүлж зэвсгээр хөөцөлдөхийг зогсоох, цөмийн зэвсгийг хураах талаар шийдвэртэй арга хэмжээ авахад зайлшгүй хүргэх нь эргэлзээгүй. Энэ санаа саяхан Индонезийн «Мердека» сонин асуултад М. С. Горбачевын өгсөн хариултад ч тусгалаа олсныг эцэст нь тэмдэглэхийг хүсэж байна.

ШУА-ИЙН ДОРНОДАХИНЫ
СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН
С. ДАШЦЭВЭЛ: ТҮҮХИЙН
УХААНЫ ДЭД ЭРДЭМТЭН:

ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН СҮҮЛИЙН
ҮЕИЙН БАЙДАЛ: ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ШИНЭ АЛХАМ

ЗХУ-ын Коммунист Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. Горбачев өнгөрсөн онд Владивостокт дэвшүүлсэн энх тайвны программд Ази, Номхон далайн районд анх тайван хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд тэнд байгаа хурцадмал байдлын голомтуудыг зохицуулахын чухлыг тэмдэглэсэн. Ази, Номхон далайн бүс нутагт эдүгээ дэлхийн олон нийтийн анхаарлыг татаж байгаа хурцадмал байдлын голомт нэлээд байгаагийн нэг нь Зүүн өмнөд Ази билээ.

Энэтхэг-Хятадын хойгийн гурван орны ялалтын дараа Кампучийн эргэн тойронд болсон хэрэг явдлыг далимдуулан империалист болон харгис хүчний зүгээс хийсэн явуулга, мөн социализм, нийгмийн дэвшлийн нөлөө бэхжихээс болгоомжилсон АСЕАН-ны орнуудын зарим эрх баригчдын бодлогын уршгаар бүс нутгийн байдал хурцдаж, Кампучи-Тайландын хил дээр зэвсэгт мөргөлдөөн, хорлон сүйтгэх ажиллагаа бүтэн долоон жил ч ашиггүй, зөвхөн империалист хүчинд л ашигтай болохыг өнгөрсөн цаг хугацаа харууллаа. Нөгөө талаар Зүүн Өмнөд Азийн нийт орнуудад тулгарсан эдийн засаг нийгмийн олон асуудлыг шийдвэрлэхэд бүс нутгийн намжмал байдал хамтын ажиллагаа чухал байна. Үүний улмаас бүс нутгийн асуудлыг хэлэлцээ хийж улс төрийн аргаар зохицуулах гэсэн хандлага тус районд улс хүчтэй

болж байна. Сүүлийн үед АСЕАН-ны орнуудыг төлөөлж Индонез, Энэтхэг-Хятадын гурван орныг төлөөлж БНСВУ нэг биш удаа уулзаж санал бодлоо солилцов. Мөн Зүүн Өмнөд Азийн хоёр бүлэг улсуудын хооронд албан ёсны төлөөлөгчид, сэтгүүлчид, эрдэмтэд солилцох, симпозиум зохиох, худалдаа эдийн засгийн зарим хэлэлцээ хийж эхлэх зэрэг зарим нааштай практик алхамууд хийгдэж байна.

АСЕАН-ны орнууд бүс нутгийн хэд хэдэн асуудлаар Энэтхэг-Хятадын хойгийн гурван оронтой адил буюу ойролцоо байр суурь баримталж байна. Нэгд, Зүүн Өмнөд Азийг энх тайван тогтвортой байдал, хамтын ажиллагааны бүс болгох саналын хувьд ойролцоо чиг шугам баримталж байна. Хоёрт, Кампучийн асуудлыг энх тайван улс төрийн аргаар шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналыг АСЕАН-ны орнууд дэмжиж байна. Гуравт, ЗӨА-ийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай ихэнх орнууд санал нэг байна. Энэ бүхэн нь бүс нутгийн хурцадмал байдлыг энх тайвнаар хамтран шийдвэрлэх бодит боломж байгааг харуулж байна.

Зүүн өмнөд Азийн хурцадмал байдлыг намжаах асуудал юуны өмнө Кампучийн эргэн тойронд болж байгаа хэрэг явдлыг эв зүйгээр зарцуулах явдалтай нягт холбоотой. Зүүн Өмнөд Азийн хоёр бүлэг улс Кампучийн асуудлыг энх тайван улс төрийн аргаар шийдэх нь зүйтэй гэсэн нэг саналтай байгаа боловч энэ чиг шугамыг яаж хэрэглэх вэ гэсэн тодорхой асуудал дээр санал зөрж байна. Тухайлбал АСЕАН-ы орнууд Кампучийн асуудлыг энх тайван, улс төрийн аргаар шийдвэрлэхдээ юуны өмнө Вьетнамын цэргийг Кампучаас бүрэн зав гаргах, түүний үндсэн дээр олон улсын хяналтын дор бүх нийтийн сонгууль явуулах замаар шийдэх санал тавьж байна.

Энэтхэг Хятадын хойгийн гурван орны хувьд бол Кампучийн дотоод хэрэгт хөндлөнгөөс ямарваа байдлаар оролцох, гадаадын нутаг дэвсгэрийг БНХАУ-ын эсрэг ашиглах явдал зогсохын хамт Кампучаас Вьетнамын дурын цэргийг бүрэн гаргах, дараа нь бүх нийтийн сонгууль явуулж эвслийн засгийн газар эмхлэн байгуулах саналтай байна.

Ийнхүү зангилаа гол асуудал дээр санал зөрөөтэй байгаа нь асуудлыг шийдэхэд бэрхшээл учруулж байна. Гэвч БНКАУ-ын засгийн газар үндэстний эвлэрлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар Кампучийн асуудлыг эв зүйгээр зохицуулах шинэ шинэ эрэл хайгуул хийсээр байна. Саяхан Нородом Сианук болон Кхмерийн сөрөг бүлэглэлүүдийн бусад толгойлогчидтой хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа БНКАУ-ын засгийн газар мэдэгдсэн нь үүний нэг тод жишээ бөгөөд асуудлыг нийт Кампучи үндэстний болон холбогдох талуудын эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэхэд чиглэсэн чухал алхам юм.

БНКАУ-ын үндэстний эвлэрлийн бодлого нь Зүүн өмнөд азийн байдлыг бүрэн хэвийн болгох гэсэн БНКАУ-ын чин эрмэлзлийг илтгэн харуулж байгаагийн зэрэгцээ олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэх дэлхийн янз бүрийн районы түгшүүртэй голомтыг арилгахад чиглэсэн шинэ хандлагын нэгэн тод жишээ болж байна гэж монголын олон нийт үзэж байна.

ШУА-ИЙН ДОРНОДАХИНЫ
СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
АЖИЛТАН Д. ПҮРЭВ:

ӨМНӨД АЗИ ЭНЭТХЭГИЙН ДАЛАЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛ
ӨНӨӨГИЙН ШАТАНД

Өмнөд Ази, Энэтхэгийн далай бол олон улсын худалдаа, эдийн засаг, усан зам харилцаа, цэрэг стратегийн чухал бүс нутаг юм. Азийн энэ хэсэгт энх тайван, тогтвортой байдлыг хангах, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Азийн өргөн уудам нутаг, далай тэнгист энх тайван, аюулгүй байдлын иж бүрэн систем бий болгох зорилтын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Нийгмийн өөр өөр байгууламжтай улсуудын харилцааны үндэс болсон «Панча шила», Бандунгийн зарчмууд, мөн империализм, колоницлол, шинэ колоницлол, апартейд бодлогын эсрэг энх тайван, тогтвортой байдал, олон улсын эдийн засгийн шударга дэг журам тогтоохын төлөө тэмцэж байгаа орчин үеийн биеэ даасан нөлөө бүхий хүч эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үндэс суурийг тавилцах, зохион байгуулалтын талаар бэхжүүлэхэд Өмнөд Азид орших дэлхийн томоохон гүрний нэг болох Энэтхэг улс чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

Өнөөгийн олон улсын харилцааны тулгамдсан асуудал болж байгаа цөмийн дайны аюулаас хүн төрлөхтнийг сэрэмжлэхийн төлөө тэмцэлд Өмнөд Азийн улсуудын дотроос Энэтхэг улс жинтэй нэмэр хандив оруулж байгаа юм. «Дэлхий ертөнцийг цөмийн зэвсэггүй, хүчирхийлэлгүй болгох зарчмын тухай» Делийн тунхаглал, цөмийн зэвсгийн эсрэг тэмцэх зарчим гэж зүй ёсоор нэрлэж болох чухал баримт бичигт Энэтхэг, ЗХУ-ын удирдагчид 1986 оны сүүлчээр гарын үсэг зурж, тус хоёр улс цөмийн зэвсэг хэрэглэх, хэрэглэхээр сүрдүүлэхийг хориглосон Олон улсын конвенц боловсруулж байгуулах талаар санал дэвшүүлж, мөн Энэтхэг улсын санаачлага, идэвхтэй оролцоотойгоор «Делийн зургаагийн» цөмийн зэвсгийг туршихыг хориглох, устгах тухай санал гаргасан зэрэг нь энэ аюулт зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах замд тодорхой алхам болж байгаа юм.

Өмнөд Азийн орнууд, Энэтхэгийн засгийн газар бүс нутгийн байдлыг хэвийн болгох, хоёр талын болон бүс нутгийн хэмжээнд итгэлцэл, оновчтой хамтын ажиллагааны уур амьсгал бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байна. 1985 онд Энэтхэг, Бангладеш зэрэг орны санаачлагаар Өмнөд Азийн орнуудын хамтын ажиллагааны бүсийн холбоо (СААРК) байгуулагдсан юм. Одоо энэ байгууллагыг бүх талаар бэхжүүлэхэд Өмнөд Азийн улсууд дор бүрээ, хүчин чармайлт тавьж байна. Дээрх байгууллагын гишүүн орнуудын дээд болон сайд нарын хэмжээнд болсон уулзалтуудаар худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник, зам харилцаа, тээвэр, холбоо харилцаа, биеийн тамир, спортын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой асуудлыг авч хэлэлцэж зарим үр дүнд хүрч байна. Мөн хоёр талын маргаантай асуудал, цэрэг, зэвсгийн хэт төвлөрлийг намжаахад чиглэсэн яриа хэлцээ, хэлэлцээ хийж практик арга хэмжээ авч байна. Хэдийгээр Өмнөд Азийн улсуудын олон улсын тулгамдсан асуудалд хандах байр суурь ялгаатай боловч, бүс нутгийн хамтын ажиллагаанд гарсан дээрх нааштай хандлага нь энэ районд улс төрийн уур амьсгалыг зөөлрүүлэх, хамтын ажиллагааны найдвартай үндэс суурийг бий болгох чиглэлд чухал урьдчилсан нөхцөл бүрэлдүүлэх ач холбогдолтой юм.

Өмнөд Азийн улсуудын харилцаанд бий болсон нааштай хандлага, олон улсын тавцанд болон эвсэлд нэгдээгүй улсуудын дотор Энэтхэгийн нөлөө, нэр хүнд улам өсч байгаа нь америкийн империализмаас Өмнөд Азийн бүс нутагт явуулж байгаа улс төр, цэрэг-стратегийн бодлогод тодорхой няцаалт болж байна. Чухам энэ байдал америкийн засаг захиргаанаас энэ бүс нутагт хэрэгжүүлэх стратегийн бодлогынхоо арга хэлбэрийг нэлээд уян хатан болгоход хүргэж байна. Энэ нь нэг талаас Пакистан, Бангладеш, Шри Ланка зэрэг улсуудтай АНУ цэрэг, улс төр, эдийн засгийн талаар ойртох бодлогоо улам идэвхжүүлэх замаар тэднийг Америкийн бодлогод өргөн хамруулах цаашлаад энэтхэг, дээрх улсуудын хоорондын маргаан, зөрчлийг хурцатгах замаар Энэтхэгт даралт шахалт үзүүлэхийг хичээж байна. Энэ бүгдийн эцсийн зорилт нь Өмнөд Ази, Энэтхэгийн далайн чиглэлээр явуулах АНУ-ын бодлогыг Өмнөд Азийн улсуудын нэгдлийг задлан бутаргах, энэ бүс нутагт энх тайван, тогтвортой байдал, үр ашигтай хамтын ажиллагааны үндэс суурийг бий болгоход саад бэрхшээл учруулахад оршиж байна.

Пакистан Өмнөд болон баруун өмнөд Ази дахь АНУ-ын цэрэг-стратегийн гол түшиц нутаг ажээ. АНУ 1987—1993 онд 4,02 млрд долларын цэрэг-эдийн засгийн тусламжийг Пакистанд үзүүлэх бөгөөд энэ тусламжийн хүрээнд америк Зия Ульхакийн цэргийн дэглэмд орчин үеийн цэргийн техник, технологи, тооцоолон бодох хэрэгсэл, стратегийн зэвсэг нийлүүлэхээс гадна цэргийн мэргэжилтэн бэлтгэх, Пакистаны нутаг дээр байгаа усан боомтууд, цэргийн баазуудыг өргөтгөж шинэчлэхэд туслах юм. Пакистан улс америкийн «Төв командлалын гишүүн орны хувьд америкийн цэргийн анги, салбарыг өөрийн нутаг оруулах үүрэг хүлээж байгаагаас гадна өөрийн зэвсэгт хүчнээс дээрх байгууллагад 10 гаруй мянган цэрэг офицерыг нийлүүлэх юм. Пакистан улс өөрийн нутаг дэвсгэр дээр Афганистаны хувьсгалын эсэргүүчүүдийн бүлгийг орогнуулж тэднийг Америк, өрнөдийн орнууд, Израиль, Хятадын зэр зэвсгээр хангах, хорлон сүйтгэх үйл ажиллагаанд бэлтгэхэд идэвхтэй оролцож байна. Америк, Пакистан хоёр Афганистаны эргэн тойронд бий болсон асуудлыг улс төрийн аргаар зохицуулахад бэрхшээл учруулсаар байна.

Бид энд мөн Энэтхэгийн далайн олон улсын статусыг хатуу чанд сахих, түүнийг цөмийн болон бусад төрлийн зэвсгээс чөлөөт, энх тайвны бүс болгоход АНУ өөрийн шинэ глобализмын бодлого, стратегийн ашиг сонирхлын үүднээс олон жилийн туршид саад бэрхшээл учруулж байгааг ярих нь зүйтэй юм. Энэтхэгийн далайг энх тайван, хамтын ажиллагааны бүс болгох асуудалд хэдийгээр Өмнөд Ази, далайн эрэг орчмын том жижиг улсуудын язгуур эрх ашигтай салшгүй холбоотой боловч олон улсын чөлөөт усан зам харилцааны чухал зангилаа нутаг болохын хувьд ЗХУ болон бусад орнуудын худалдаа, эдийн засаг, зам харилцааны аюулгүй байдлын ашиг сонирхлыг зүй

ёсоор хөндөж байгааг мөн харгалзан үзвэл зохино. Тиймээс ч ЗХУ, социалист орнууд Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгох асуудлыг олон улсын хэмжээнд авч хэлэлцэх, энэ районд цэрэг зэвсгийн хэт их төвлөрлийг багасгах, гадаадын цэргийн баазыг татан буулгах, энэ зорилгоор Энэтхэгийн далайн асуудлаар олон улсын бага хурлыг 1988 оноос хэтрүүлэлгүй зарлан хуралдуулахын төлөө байгаа юм.

Тус сэтгүүлийн редакциас зохион явуулсан «Дорнодахины Дугуй ширээ» нэрт эчнээ ярилцлагад манай урилгыг хүлээн авч өндөр ухамсарын үүднээс ажил хэрэгчээр оролцож орчин үеийн олон улсын харилцааны зангилгаа асуудлын нэг болох Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын төлөө тэмцлийн сэдвээр уншигчидтай санал бодлоо хуваалцсан хүндэт нөхөдөд гүн талархал илэрхийлж байна.

РЕДАКЦИ